

-
19. European Border and Coast Guard Agency, (2021). In Brief 2020, Luxembourg, Publications Office of the European Union.
20. James, R.P., Jeffrey, D., Monica, K. (2018). "Border Security", Carolina Academic Press, Durham, 370-373.
21. OSCE, "Border Security and Management Concept", (2005).
- Organization for Security and Co-operation in Europe Ministerial Council, Ljubljana, MC.DOC/2/05, osce.org.
22. Vulfson, B. L., (2002). "Methods of Comparative Education Researches", Pedagogica, Volume 2, 70-80.
23. Улсын хил хамгаалалт, bpo.gov.mn

ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИ, САЛБАРУУДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН, ШИНЖИЛГЭЭ

Б.Цэдэндамба

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээг гурван чиглэлээр хийн, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангахад анхаарах талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, нөлөөлөх хүчин зүйл, шинжилгээ, анхаарах зарим асуудал.

Key words: Security, border security, current status, legal regulation, some issues for improvement.

Оршил

Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохын тулд:

Нэг. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай онолын мэдлэг ямар төвшинд байгаа болон орчны үнэлгээнд хийсэн тойм судалгаа;

Хоёр. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар судалгаа хийлээ.


Судалгаанаас тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг

хангахад анхаарах зарим санал дэвшүүлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг.

Нэг. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, орчны үнэлгээний талаар гурван ангийн нийт 144 цэргийн алба хаагчдаас доорх 7 асуулгаар судалгаа авлаа.

1. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай таны ойлголтын талаар судалгаанд оролцсон цэргийн алба хаагчдын 106 буюу 73.6 хувь нь мэднэ, 24 буюу 16.6 хувь нь мэдэхгүй, 14 буюу 9.8 огт ойлголтууд гэж тус тус хариулсан байна.




Зураг 1. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай ойлголт.

2. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал нь Хилийн цэргийн албаны аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хилийн цэргийн анги,

салбарын байр, объект, орчны аюулгүй байдал, хилийн цэргийн алба хаагчийн аюулгүй байдлын тухай ойлголтууд тус тус хамаарна” гэж үзэж байна. Та дээрх


тодорхойлолт, ойлголттой санал нэгдэж байна. уу гэсэн асуултанд 114 буюу 79 хувь нь тийм, 14 буюу 10 хувь

нь ойлголтгүй, 16 буюу 11 хувь нь огт мэдэхгүй гэж тус тус хариулсан байна.



Зураг 2. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай ойлголт.


3. Хилийн цэргийн ангийн хамрагдагсдын 50 хувь нь дунд, 22 хувь аюулгүй байдал нь эрх зүйн хувьд нь сайн, 4 хувь маш сайн, 14 хувь нь бүрэн зохицуулагдсан уу гэсэн муу, 10 хувь нь маш муу гэж хариулсан асуултанд нийт судалгаанд байна



Зураг 3. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт.

4. Хилийн цэргийн анги, салбарын байрны бүрэн бүтэн байдал, харуул хамгаалалт өнөөгийн шаардлага хангаж байгаа эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 60 хувь нь “Дунд”, 19 хувь нь “Сайн”, 7 хувь нь муу, 13 хувь нь маш муу, 1 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

Дүгнэлт: Дээрх асуултанд судалгаанд оролцогсдын 60 хувь нь “Дунд”, 20 хувь нь сайн болон маш сайн, 20 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.




Зураг 4. Хилийн цэргийн анги, салбарын байрны бүрэн бүтэн байдал, харуул хамгаалалт өнөөгийн шаардлага хангаж байгаа эсэх.

5. Алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд байгаа эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын маш сайн гэж хариулаагүй бөгөөд 50 хувь нь “Дунд”, 28 хувь нь “Сайн”, 17 хувь нь муу, 5 хувь нь маш муу гэж хариулсан байна.

Дүгнэлт: Дээрх асуултанд судалгаанд оролцогсдын 50 хувь нь


“Дунд”, 28 хувь нь сайн болон маш сайн, 22 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд бүрэн хүрэхгүй байгаа, тэдний энэхүү мэдлэгийг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.



Зураг 5. Алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд байгаа эсэх.

6. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдсэн эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын маш сайн гэж


хариулаагүй бөгөөд 44 хувь нь “Дунд”, 20 хувь нь “Сайн”, 21 хувь нь муу, 15 хувь нь маш муу гэж тус тус хариулсан байна.



Зураг 6. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдсэн эсэх.

7. Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээтэй эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 42 хувь нь “Маш муу”, 27 хувь нь “Муу”,

25 хувь нь “Дунд”, 2 хувь нь маш сайн, 4 хувь сайн гэж тус тус хариулсан байна.



Зураг 7. Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээтэй эсэх.

Дээрхээс нөхцөл байдлын судалгаа (орчны судалгаа)-г дүгнээд үзэхэд хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын нэр томъёо, тодорхойлолтын талаар судалгаанд оролцогсдын ойлголт хэвийн;

ХЦААБ-ыг хангах асуудал нь эрх зүйн хувьд хэвийн хэмжээнд зохицуулагдсан болохыг илэрхийлсэн бөгөөд өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатайг харуулсан;

ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатай;

Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдээгүй, техник технологийн хангалтыг шинэчлэх, сайжруулах шаардлагатай;

Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээгүй, шаардлагын түвшинд хүрэхгүй учир дутагдалтай гэж тус тус дүгнэгдсэн.

Орчны судалгаанаас хилийн цэргийн анги, салбарын аюулгүй байдалд техник, технологийн хангалт дутмаг, цалин хангамжийн хүрэлцээ

муу, сэтгэл дундуур байна. Цаашид дээрх хоёр асуудалд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

Хоёр. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар хилийн цэргийн гурван ангийн 144 цэргийн алба хаагчдаас судалгаа авч судлан шинжиллээ. Үүнд:

2.1. Гадаад хүчин зүйл.

1. Хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал (хашаа, камер, шалган нэвтрүүлэх байр, дохиоллын систем) гэсэн судалгаанд оролцогсдын 46 хувь нь “Дунд”, 19 хувь нь сайн болон маш сайн, 10 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал хэвийн, харин камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

2. Харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 43 хувь нь “Дунд”, 51 хувь нь сайн болон маш сайн, 6 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт хэвийн байгааг илэрхийлж байна.


3. Тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдал гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 36 хувь нь “Дунд”, 46 хувь нь сайн болон маш сайн, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан, тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдал 72 хувь нь дундаас дээш байгааг илэрхийлсэн нь энэхүү харилцааны байдал хэвийн байгааг, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь энэхүү харилцааг илүү сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

4. Тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 29 хувь нь

“Дунд”, 53 хувь нь сайн болон маш сайн, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь сайн байгааг илэрхийлж байна зэрэг 15 асуулгаар гадаад хүчин зүйлийн нөлөөллийг тодорхойлсон.

2.2. Дотоод хүчин зүйл.

1. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчин хангалттай эсэх гэсэн судалгаанд оролцогсдын 51 хувь нь “Дунд”, 33 хувь нь сайн болон маш сайн, 16 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчний хангалт хэвийн, хангалттайг илэрхийлж байна.



Зураг 7. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчин хангалттай эсэх.

2. Алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан эсэх гэсэн судалгаанд оролцогсдын 45 хувь нь “Дунд”, 25 хувь нь сайн болон маш сайн, 30 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь Алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан байдлыг 75 хувь нь бүрэн хангадаагүй буюу дундаас доош түвшинд үнэлсэн нь алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

Аюулгүй байдлын онолоор “аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг

хүчин зүйл” гэдэг нь үндсэндээ төр, нийгэм, бие хүний (иргэний) язгуур эрх ашигт аюул учруулж буй хүчин зүйлс, нөхцөл байдлын нэгдэл юм. Энэхүү ойлголтод тулгуурлан ХЦААБ-д нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөллүүдийг:

- ХЦААБ-ын тухай ойлголт болон орчны нөлөөллийн хүчин зүйлийн шинжилгээг 7 асуулгаар;

- ХЦААБ-д нөлөөлж буй гадаад хүчин зүйлийн нөлөөллийг 15 асуулгаар;

- ХЦААБ-д нөлөөлж буй дотоод хүчин зүйлийн нөлөөллийг 25 асуулгаар боловсруулан, дээрх асуулгуудаар хилийн цэргийн гурван ангийн 144 алба хаагчдаас судалгаа авч шинжилгээ хийлээ.

Дүгнэлт:

Нэг. Гадаад орчны шинжилгээ.

Давуу тал:

- нөхцөл байдлын судалгаа (орчны судалгаа)-г дүгнээд үзэхэд хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын нэр томъёо, тодорхойлолтын талаар судалгаанд оролцогсдын ойлголт сайн;

- харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт хэвийн, сайн;

- тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдлыг судалгаанд оролцогсдын 72 хувь нь дундаас дээш байгааг илэрхийлсэн нь энэхүү харилцааны байдал хэвийн, сайн байгааг харуулсан;

- тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь сайн;

- орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагууд болон хилийн цэргийн ангийн харилцан ажиллагаа маш сайн;

- тухайн анги, салбарын байрлал зөв газраа байрласан;

- улсын хилийн аюулгүй байдлыг хангасан байдал нь сайн байна.

Сул тал:

- ХЦААБ-ыг хангах асуудал нь эрх зүйн хувьд хэвийн хэмжээнд зохицуулагдсан болохыг илэрхийлсэн бөгөөд өнөөгийн нөхцөл байдалтай

уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатайг харуулсан;

- ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатай;

- хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдээгүй, техник технологийн хангалтыг шинэчлэх, сайжруулах шаардлагатай;

- хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал хэвийн, харин камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатай;

- орон нутгийн бизнес, эдийн засгийн нөхцөл байдал сайн биш, хангалтгүй;

- хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 70 хувь нь, нөлөөлөхгүй гэж судалгаанд оролцогсдын 30 хувь нь илэрхийлсэн;

- улсын хил дээр үүссэн эмх замбараагүй байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 64 хувь нь, нөлөөлөхгүй гэж судалгаанд оролцогсдын 36 хувь нь илэрхийлсэн;

- цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгаль цаг уурын байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 88 хувь нь үзсэн;

- тухайн орон нутгийн байгууллага, иргэдээс нөлөөлөх ашиг сонирхол ХЦААБ-д 29 хувийн муугаар нөлөөлж болзошгүй;

- хилийн цэргийн анги, салбар дахь улс төрийн нөлөөлөл нь ХЦААБ-д 40 хувийн муугаар нөлөөлж болзошгүй;

- гамшиг, аюул осол, гал түймэр, гол усны үер, газар хөдлөлтийн аюулгүй байдал нь хангалттай хангагдаагүй;

- хилийн цэргийн ангийн техникийн хангалтын боломж нь хангалтгүй, энэ нь ХЦААБ-д 48 хувийн сөргөөр нөлөөлж болзошгүй;

- алба хаагчдын цалин хангамж хүрэлцээгүй, шаардлагын түвшинд хүрэхгүй учир дутагдалтай гэж тус тус дүгнэгдсэн.

Дээрх гадаад орчны судалгаанаас дараах тулгамдаж буй асуудал байна. Үүнд:

- өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатай;

- хилийн цэргийн анги, салбарын аюулгүй байдалд техник, технологийн хангалт дутмаг, алба хаагчдын цалин хангамжийн хүрэлцээ муу, сэтгэл дундуур байна;

- түүнчлэн орон нутгийн бизнес, эдийн засгийн нөхцөл байдал сайн биш, хангалтгүй, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгаль цаг уурын байдал, гамшиг, аюул осол, гал түймэр, гол усны үер, газар хөдлөлт, тухайн орон нутгийн байгууллага, иргэдээс нөлөөлөх ашиг сонирхол, хилийн цэргийн анги, салбар дахь улс төрийн нөлөөлөл ХЦААБ-д 40-88 хувийн сөргөөр нөлөөлөх магадлалтай;

- албаны үйл ажиллагааны хувьд хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил, улсын хил дээр

үүссэн эмх замбараагүй байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө;

- камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатай зэрэг болно. Эндээс цаашид эдгээр асуудалд бодлогын болоод удирдлага, зохион байгуулалтын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

Хоёр. Дотоод орчны шинжилгээ.

Давуу тал:

- алба хаагчдын мэргэжлийн ур чадвар хэвийн, чадварлаг боловсон хүчний хангалт сайн;

- хилийн цэргийн ангийн тасаг албадын уялдаа холбоог 83 хувь нь дундаас дээш сайн, хэвийн гэж үзсэн;

- шат дараалсан хяналт, шалгалт маш сайн явагддаг;

- тушаал, дүрэм, журам, зааврын хэрэгжилт хэвийн;

- алба хаагчдын хоорондын харилцаа, зарчимч шаардлага сайн;

- алба хаагчдын албанд хандах хандлага (үнэнч, шударга байдал) сайн;

- алба хаагчдын гэр бүлийн байдал тогтвортой, хэвийн сайн;

- алба хаагчдын сахилга, хариуцлагын байдал хэвийн сайн;

- алба хаагчдын ёс зүй хэвийн сайн;

- алба хаагчдын албаны мэдлэг, туршлага хэвийн сайн;

- алба хаагчдын аюулгүй байдал, эрсдэлийн мэдлэг хэвийн;

- харуул хоногийн манааны тохироо маш сайн;

- хилийн цэргийн ангийн албаны зохион байгуулалт сайн;

- зэвсэг галт хэрэглэл, тавиулан, агуулахын хадгалалт, хамгаалалт сайн;

- нууц хадгалалт, хамгаалалтын байдал маш сайн;

- мэдээллийн аюулгүй байдал сайн;

- алба хаагчдын хүнсний аюулгүй байдал хэвийн;

- алба хаагчдын үүрэг гүйцэтгэх орчин нөхцөл (өрөө тасалгаа) хэвийн;

- алба хаагчдын хувцас хэрэгслийн хангалт хэвийн хэмжээнд сайн зэрэг болно.

Сул тал:

- алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан байдлыг 75 хувь нь бүрэн хангагдаагүй буюу дундаас доош түвшинд үнэлсэн нь алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах шаардлагатайг илэрхийлсэн;

- цалин хангамжийн хүрэлцээтэй байдал хангалтгүй, цалин хангамж нэмэх шаардлагатай;

- төсвийн зүй зохистой хуваарилалтад анхаарах шаардлага байгаа;

- алба хаагчдын ажлын ачаалал дундаас дээш их;

- алба хаагчдын амьжиргааны түвшин хангалтгүй муу;

- цэргийн дүрмийн бус харилцаа тодорхой хэмжээнд байгааг 22 хувь нь илэрхийлсэн болно.

Дээрх дотоод орчны судалгаанаас дараах тулгамдаж буй асуудал байна. Үүнд:

- алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах;

- цалин хангамж нэмэх шаардлагатай;

- алба хаагчдын ажлын ачаалал дундаас дээш их;

- алба хаагчдын амьжиргааны түвшин хангалтгүй;

- цэргийн дүрмийн бус харилцаа тодорхой хэмжээнд байгаа зэрэг болно.

Иймд эдгээр асуудалд бодлогын болоод удирдлага, зохион байгуулалтын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

ХЦААБ-ын гадаад, дотоод орчинд хийсэн дээрх судалгаанд үндэслэн хилийн цэргийн анги, байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах ажиллагаанд дараах нөхцөл байдлуудыг анхааран, үйл ажиллагаагаа чиглүүлж болох юм. Үүнд:

Гадаад хүчин зүйлс:

- улс орны эдийн засгийн хүндрэл;

- байгалийн аюул гамшиг (ган, зуд, гал усны аюул, газар хөдлөлт, гоц халдварт өвчин тархах);

- шударга бус өрсөлдөөнөөс үүдэн байгууллагуудын хооронд үл ойлголцох байдал бий болох;

- гэмт бүлэглэл буюу гэмт этгээдийн халдлага;

- ангийн нэр хүндэд санаатай болон санамсаргүйгээр халдах;

- хамт олны эгнээнд таагүй этгээд шургалах;

- өөр байгууллага, этгээдийн буруугаас осол аваар гарах, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирох;

- гадны байгууллага хувь хүний нөлөөнд автаж, буруу үйл ажиллагаа явуулах;

- гадны нөлөөгөөр чухал мэргэжлийн болон авьяас чадвартай хүмүүсээ алдах;

- гадны нөлөөнд автан удирдах ажилтнуудын гар нийлэмжтэй ажиллагаа болон хамт олны санал сэтгэгдэл алдагдах, ажлын идэвх буурах;

- буруу, ташаа мэдээлэл авснаас буруу шийдвэр гаргах;

- томилогдон ирж буй офицер, ахлагч нар ажлын шаардлага, хэрэгцээг хангахгүй байх;

- дээд шатны байгууллагаас ангийн үйл ажиллагаа, бодит байдлыг өрөөсгөл буруу дүгнэх, улс төрийн нөлөө орох;

- техник, технологийн хоцрогдолд орох;

- нийгмийг хамарсан ядуурал, гэмт хэргийн өсөлт;

- бие бүрэлдэхүүний ар гэрт тохиолдсон бэрхшээлээс үүдэн таагүй байдал бий болох (гэр бүлийн гишүүдээс гэмт хэрэгт холбогдох, тааламжгүй байдал, хүнд өвчлөх, үхэл зовлон тохиолдох, аюул гамшигт өртөх) зэрэг болно.

Санал.

Дээрх хүчин зүйлс, нөлөөллөөс хамгаалж үндсэн үүргээ бүрэн биелүүлэхийн тулд дараах ажлуудыг зохион байгуулах саналтай болно.
Үүнд:

- бүх төрлийн нөөцтэй байх;

- материал хэрэгслийг зүй зохистой зарцуулж ашиглах өөрсдийн хүчинд тулгуурладаг байх;

- ангийн байрлалд орж гарах, гадны хүнтэй уулзах журмыг хатуу чанд сахих, бүх газрыг харуул, манааны хяналтад байлгах;

- гэнэтийн халдлага, хулгай дээрэм гарсан үед явуулах ажиллагааг төлөвлөж, дадлага, сургууль хийх, бие бүрэлдэхүүнийг бие хамгаалах урлагийн зохих бэлтгэлтэй болгох;

- шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангаж, офицер, ахлагч нарын албаны мэдлэгийг сайжруулах;

- айл өрхийн судалгааг тодорхой хийж, офицер, ахлагч, ажилчдын ар гэрт анги, хамт олны нөлөөллийг бий болгох зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын Үндсэн хууль (1992)

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (2001)

Монгол Улсын Хилийн тухай хууль (2016)

Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах тухай. (МУЕ-ийн зарлиг №180, 2022)

Монгол Улсын хилийн цэргийн штабуудын албаны заавар. (ХХЕГ-ын даргын тушаал №А/68, 2007)

Хил хамгаалах байгууллагад цэргийн албыг зохион байгуулах заавар. (ХХЕГ-ын даргын тушаал №А/259, 2019)

Дашзэвэг, Ц. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2014. 57 х. 65 х. 209 х.

Пүрэвбаасан, В. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол арга зүй. Уб., 2022. 219 х.

Улаанхүү, Ч. Аюулгүй байдал. Уб., 2009. 35 х.

Мандахбаяр, Д. Артиллерийн анги салбарын аюулгүй байдлыг хангах зарим арга зам. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2018. 48 х.

Эрдэнэцогт, Д. Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэс. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2002. 65 х.

Пүрэвбаасан, В. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол арга зүй. Хил судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.

[https://www.bolor-toli.com/dictionary/word search=security](https://www.bolor-toli.com/dictionary/word%20search=security)

<https://www.woerriam-webster.com/dictionary/sefity>